


Эхийн сэдэв, гол санаа



ЭХ ГЭДЭГ НЬ



TEXTUS БУЮУ



НЭХЭХ, СҮЛЖИХ ГЭСЭН
УТГАТАЙ ЛАТИН ҮГ.

Эх гэж юу вэ?



Тухайн гарчиг, сэдвийн хүрээнд өгүүлсэн хүн, юмс, үзэгдлийн талаарх хэд хэдэн санааг нэгтгэн, тэдгээрийг өөр хооронд нь “нэхэн сүлжиж” утга төгсгөснийг эх буюу текст гэнэ.

Эх нь харилцах болоод мэдээлэх утга, үүрэгтэй. Эх нь тодорхой шинж, юм үзэгдэл, үйл явдлыг нэгэн гол санаанд зангидсан бүхэл бүтэн бичвэр, зохиол юм.

Эхийн сэдэв

Эхийн гол утгыг гаргах гэж сэдсэн санааг сэдэв гэнэ. Сэдэв нь эхийн нэр буюу гарчиг, эхэд өгүүлэгдэж байгаа гол юмтай тохирох ч бий, тохирохгүй ч бий.

Эхийн гол санаа

Эхийн сэдвийн хүрээнд тодорхой үйл явдал, мэдрэмж, сэтгэгдэл, баримт нотолгоо, үзэл бодол зэргээр дамжуулан ямар нэгэн санаа, дүгнэлт гаргасныг эхийн гол утга санаа гэнэ. Утга санаагүй эх гэж үгүй, эхээр илэрхийлэгдэхгүй утга гэж үгүй.



Эхийн сэдэв, гол санааны ялгаа

Сэдэв	Гол санаа
Юуны тухай өгүүлсэн бэ? гэдэг асуултад сэдэв хариулагдана.	Хэрэг явдал яаж төгсөж, ямар дүгнэлтэд хүрсэн бэ? гэсэн асуултад хариулагдана.
Өгүүлбэрээр биш нэг үг юм уу, холбоо үгээр илэрнэ.	Өгүүлбэрээр илэрнэ.
Сэдвийг эхлэл хэсэгт танилцуулдаг. Тэгэхээр эхлэл хэсэгт юуны тухай өгүүлснийг сайн ойлгох хэрэгтэй.	Цогцолбор бүрийн сэдэв, утга санаа нийлж, гол санааг бүтээх ба гол санаа буюу дүгнэлт нь төгсгөл хэсэгт илэрдэг.
Зохиол бичихээс өмнө зохиогчийн санаанд бий болсон байдаг.	Сэдвийг баримт нотолгоо, үйл явдал, мэдрэмж, үзэл бодлоор баяжуулан дүрсэлсний эцэст уншигчдад хэлэх гэсэн чухал санаа гэж ойлгож болно.
Эхэд олон давтагдсан үг буюу түлхүүр үгээр ихэвчлэн илэрдэг.	Сэдвийг багтаасан дүгнэлт шинжтэй өгүүлбэрээр илэрнэ.



“Хавар” тоочимж эхийн сэдэв, гол санааг тодорхойлъё. Үүний тулд дараах алхмаар ажиллая.

1. Гарчиг буюу нэр лүү анхаарлаа хандуулах
2. Хамгийн олон давтагдсан нэр үг буюу түлхүүр үгийг олох
3. Тухайн эх зохиол далд утгатай юу? Шууд, ил утгатай юу? гэдгийг тодорхойлно. Хэрэв далд утгатай бол эхээ дахин уншиж тухайн түлхүүр үгээр дамжуулж, юуны тухай өгүүлснийг тодорхойлох
4. Цогцолбор бүрд юуны тухай өгүүлснийг олох
5. Тухайн сэдвийн талаар төгсгөл хэсэгтээ зохиолч юу гэж дүгнэснийг олох

Хавар

Гол горхи хүсэл мэт тэмүүлэн урсана. Цэцэг ногоо бодол мэт чимээгүй ургана. Тунгалаг гэрэл, ариун үнэр арван зүгт дэлгэрнэ. Дуу чимээ алслан түгж, цэнхэр ногоон хоёр өнгө хослон жигдэрнэ. Салхи урьхнаар мяралзан ирж, уйтгарыг аван одно.

Хүний зүрхэнд баяр гийж, хүлгийн туурайнаас ногоо ханхлахад хэрээ хүртэл сөөнгө хоолойгоор хаврын дуу дуулна.

Гэнэт яав, юу болов гэмээр салхи догшрон ирж, согтуу хүн шиг хаалга цонх балбана. Хөрст дэлхий хөх тэнгэрт гарчихав уу? гэмээр орчлон ертөнц булингартан эргэлдэж, од гариг мөргөлдөн унах шиг болно. Тэгснээ орой тийшээгээ яагаа ч үгүй юм шиг нам гүм урьдынхаасаа гойд сайхан шөнө болно. Эргэн тойрон цэцэг ургамал, ногоо дэлгэрч байгаа юм шиг нам гүм байтал дахиад л галуу ганганана...

Хавар би аз жаргалтай гэж өөрийгөө бодно. Хаврын тэнгэр голдуу л хүүхдийн нүд шиг тунгалаг байна. Цагийн цагт тэнгэр хүүхдийн нүд шиг байгаасай гэж хавар би улам ихээр хүснэ.

Д.Батбаяр

Хавар эхийн сэдэв, гол санааг тодорхойлъё. Үүний тулд дараах алхмаар ажиллая.

1. Гарчиг буюу нэрийг анхаарах
2. Хамгийн олон давтагдсан нэр үг буюу түлхүүр үгийг олох
3. Тухайн эх зохиол далд утгатай юу? Шууд, ил утгатай юу? гэдгийг тодорхойлно. Хэрэв далд утгатай бол эхээ дахин уншиж тухайн түлхүүр үгээр дамжуулж, юуны тухай өгүүлснийг тодорхойлох
4. Цогцолбор бүрд юуны тухай өгүүлснийг олох
5. Тухайн сэдвийн талаар төгсгөл хэсэгтээ зохиолч юу гэж дүгнэснийг олох

Гарчиг буюу нэр



Сэдэв

Хавар

Өгүүлэгдэж байгаа юмс



Түлхүүр үг



Гол хэсгийн хэрэг явдал



Эхийн төгсгөл



Гол санаа

Гол горхи хүсэл мэт тэмүүлэн урсана. Цэцэг ногоо бодол мэт чимээгүй ургана. Тунгалаг гэрэл, ариун үнэр арван зүгт дэлгэрнэ. Дуу чимээ алслан түгж, цэнхэр ногоон хоёр өнгө хослон жигдэрнэ. Салхи урьхнаар мяралзан ирж, уйтгарыг аван одно.

Хүний зүрхэнд баяр гийж, хүлгийн туурайнаас ногоо ханхлахад хэрээ хүртэл сөөнгө хоолойгоор хаврын дуу дуулна.

Гэнэт яав, юу болов гэмээр салхи догшрон ирж, согтуу хүн шиг хаалга цонх балбана. Хөрст дэлхий хөх тэнгэрт гарчихав уу? гэмээр орчлон ертөнц булингартан эргэлдэж, од гариг мөргөлдөн унах шиг болно. Тэгснээ орой тийшээгээ яагаа ч үгүй юм шиг нам гүм урьдынхаасаа гойд сайхан шөнө болно. Эргэн тойрон цэцэг ургамал, ногоо дэлгэрч байгаа юм шиг нам гүм байтал дахиад л галуу ганганана...

Хаварт би аз жаргалтай гэж өөрийгөө бодно. Хаврын тэнгэр голдуу л хүүхдийн нүд шиг тунгалаг байна. Цагийн цагт тэнгэр хүүхдийн нүд шиг байгаасай гэж хавар би улам ихээр хүснэ.